

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг: Өнөөгийн нөхцөл байдал

Хэнтий аймгийн хүн амын тоо 77684 бөгөөд МУ-ын нийт хүн амын 2,4 хувийг эзэлж байна. Үүнээс 50.5 хувийг эрэгтэйчүүд 49.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. 2019 оны байдлаар 184 төрийн байгууллагад 4509 төрийн албан хаагч ажиллаж байна. Үүнээс эрэгтэй 1460 буюу 32%, эмэгтэй 3049 буюу 68%-ийг эзэлж байна.

Удирдах албан тушаалтан 377 байгаагаас 45 хувь нь эмэгтэй, гүйцэтгэх албан тушаалтан 2959 байгаагаас 67.5 хувь нь эмэгтэй, туслах албан тушаалтан 1173 байгаагаас 76.7 хувь нь эмэгтэй ажилтан байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 57 хувь нь эрэгтэйчүүд, 48 хувь нь 15-34 насны залуучууд байна. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүд 2020 оны 01 сард 502 иргэн байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 266 хүнээр өссөн бөгөөд 286 /57%/ нь эмэгтэйчүүд байна.

2019 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн 6 төсөл хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор 1187 иргэнд 1 тэрбум 338,7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, ажилгүй, ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, ажилгүйдэлд өртөж болзошгүй 1043 иргэнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгч, бүлгийн сургалтанд 1050 иргэнийг хамруулж 218 ажил олгогчийн 1263 ажлын байрны захиалгад 1205 иргэнийг байнгын болон түр ажлын байранд н зуучилснаас 949 буюу 78% нь байнгын ажлын байртай болсон.

Хэнтий аймгийн цалингийн дундаж хэмжээ 726,4 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 305,4 мянган төгрөгөөр буюу 29,5 хувиар бага байна. Эрэгтэйчүүдийн дундаж цалин 862,9 мөнгөн төгрөг, харин эмэгтэйчүүдийн дундаж цалин 663,3 мянган төгрөг байгаа нь эрэгтэйчүүдийн дундаж цалингаас 139,6 мянган төгрөгөөр буюу 16 хувиар бага байна.

Хэнтий аймгийн хувьд ядуурлын түвшин 43.8 байгаа нь улсын дунджаас 14,2 хувиар, Улаанбаатар хотоос 19,8 хувиар илүү байна. Хэнтий аймаг нь ядуурлын түвшингөөр 21 аймгаас 4-д орж байна.

Үндэсний статистикийн газраас гаргасан судалгаагаар¹ эмэгтэйчүүдэд хамтрагчийн зүгээс бие мах бодын хүчирхийлэл үйлдэх болсон шалтгааны хамгийн өндөр хувь буюу 62,2 нь согтууруулах ундаа хэрэглэсэн байх үедээ үйлдэгддэг байна.

Аймгийн жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ 2019 оны судалгаанаас харахад судалгаанд оролцсон орон нутгийн төрийн албан хаагчдын 30% нь жендэрийн чиглэлээр сургалтад огт хамрагдаж байгаагүй гэсэн байна. Мөн орон нутгийн иргэдийн жендэрийн талаар ойлголт, хандлага дутмаг байна гэж дүгнэсэн. ²

Иймд жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, дээр дурдсан нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг харгалзан үзэж, үйл ажиллагааг санхүүгийн эх үүсвэрийн хамт төлөвлөх хэрэгцээ тулгарч байна.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго

Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн бодлогыг тодорхойлж, түүний хэрэгжилтийг дэмжих чадавхыг бүрдүүлэх замаар эмэгтэй, эрэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангаж, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав: Хөтөлбөрийн зорилт

1. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх чадавхыг бүрдүүлж, салбар хорооны үйл ажиллагааг өргөжүүлэх

2. Төр болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн хүрээнд жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны түншлэлийг бий болгох
3. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлэх, гомдлыг шийдвэрлэх механизмыг бүх түвшинд бий болгоно.
4. Орон нутгийн хөгжил дэх эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжиж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Дөрөв: Хамрах хүрээ

Аймгийн хэмжээнд хэрэгжилтийг ханган ажиллана.

Тав: Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2020-2021 он хүртэл.

Зургаа: Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ

7.1. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх чадавхыг бүрдүүлж, салбар хорооны үйл ажиллагааг өргөжүүлэх

7.2 Төр болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн хүрээнд жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны түншлэлийг буй болгох

7.3. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлэх, гомдлыг шийдвэрлэх механизмыг бүх түвшинд бий болгоно.

7.4. Орон нутгийн хөгжил дэх эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжиж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Долоо: Хөтөлбөрийн санхүүжилт

8.1. Жендэрийн дэд хөтөлбөрийн жилийн төлөвлөгөөний дагуу шаардагдах төсвийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгасан байх:

Найм: Үр дүн

9.1. Салбар хорооны үйл ажиллагаа тогтмолжиж, орон нутагт жендэрийн аудит хийгдсэн байна.

9.2. Орон нутагт жендэрийн чиглэлээр хөндлөнгийн үнэлгээ хийх Иргэний нийгмийн байгууллага чадавхжсан байна.

9.3. Байгууллага бүр дотоод журамдаа жендэрт суурилсан хүчирхийллээс, ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлэх, гомдлыг шийдвэрлэх механизм бүрдүүлсэн байна.

9.4. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоо нэмэгдэнэ.

¹ “Хүчирхийллийн нүцгэн үнэн” жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан-2017

² Хэнтий аймгийн жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээний тайлан, 2019 он

**ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэх	Төсөв (жилээр)	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин
1. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх чадавхыг бүрдүүлж, салбар хорооны үйл ажиллагааг өргөжүүлэх								
1	Салбарын хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах	2020-2021	Салбар хорооны нарийн бичгийн дарга	Салбар хорооны гишүүд		Хурлын тоо, салбарын хорооны төлөвлөгөөний хэрэгжилт	Салбар хороо тогтмол хуралддаггүй. Үйл ажиллагаа тогтмол биш.	Салбар хорооны үйл ажиллагаа тогтмолжиж, зохион байгуулах үйл ажиллагаа тогтмол явагдана.
2	Орон нутгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтэд жендэрийн нөхцөл байдлыг харуулсан суурь судалгааг танилцуулах	2020 оны 3-5 сард	АЗДТГ	ЖҮХ, СХэлтэс, төрийн болон ТББ		Суурь судалгаа хийгдэж дууссан байна.	Суурь судалгааны үр дүнг танилцуулаагүй.	Суурь судалгааг хийж, товхимол болгон хэвлэсэн байна.
3	Орон нутагт жендэрийн аудит хийх	2021	АЗДТГ	Жендэрийн үндэсний шинжээч	9 сая	Жендэрийн дотоод аудит хийгдсэн байгууллагын тоо	Жендэрийн дотоод аудит хийгдсэн байгууллага байхгүй.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэхэд ахиц гарсан байна.
4	Жендэрийн асуудлаарх статистик мэдээллийн нэгдсэн сантай болж, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах	2020-2021	СХ	АЗДТГазар		Хүйсээр гаргасан статистик мэдээлэл	Хүйсээр ангилсан тоон мэдээлэл хангалтгүй байна.	Орон нутгийн нийгэм эдийн засгийн болон шаардлагатай статистик мэдээллийг хүйсээр гаргасан байна.
2. Төр болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн хүрээнд жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны түншлэлийг буй болгох								
	Жендэр болон нийгмийн хөгжлийн чиглэлээр ажилладаг Иргэний	2020	АЗДТГ	ЖҮХ, Үндэсний ИНБ	6 сая	Зохион байгуулсан сургалтын тоо,	Иргэний нийгмийн байгууллага чадавхжаагүй.	3 ИНБайгууллагын гишүүдийг чадавхжуулах

1	нийгмийн байгууллагыг чадавхжуулах сургалт зохион байгуулах					хамрагдсан хүмүүсийн тоо		сургалт хамруулсан байна.
2	Орон нутгийн жөндөрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх		ИНБ	АЗДТГ	4 сая	Ажлын тайлан	Дүн шинжилгээ хийсэн тайлан байхгүй.	Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, тайланг гаргасан байна.
3	Байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтийг тооцох		АЗДТГ	ИНБ, аймаг, сумын ЗДТГ		Ажлын тайлан, хяналт үнэлгээ	Сургалтын төлөвлөгөөнд энэ талын сургалт байдаггүй	Байгууллага бүр сургалтын төлөвлөгөөнд жил бүр тусгаж хэвшсэн байна. Хэрэгжилтийг тооцсон байна.

3. Жөндөрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлэх, гомдлыг шийдвэрлэх механизмыг бүх түвшинд бий болгоно.

1	Байгууллагын өдөр тутмын хөдөлмөрийн харилцаа, ажиллах нөхцөлийг зохицуулах бодлогын баримт бичигт жөндөрт суурилсан аливаа хүчирхийллээс сэргийлэх, таслан зогсоох, гомдлыг шийдвэрлэх механизмыг суулгах		АЗДТГ	Салбар хороо		Дотоод хяналт, ажлын тайлан	Баримт бичигт тусгасан байгууллага маш цөөхөн, тусгасан байгууллагууд нь мөрдлөг болгодоггүй	Бүх байгууллага бодлогын баримт бичигт тусгасан байна. Үйл ажиллагаандаа чиглэл мөрдлөг болгон ажиллаж хэвшсэн байна.
2	Сумын ЗДТГ болон байгууллагад жөндөрийн чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаа, дотоод журамд хяналт шинжилгээ		АЗДТГ	Салбар хороо		Хяналт шинжилгээ үнэлгээний тоо, тайлан	ХШҮ хийгдэхгүй байна.	Хяналт шинжилгээ үнэлгээг хийснээр үйл ажиллагаа тогтмолжино.

	үнэлгээ хийж хэвших							
4. Орон нутгийн хөгжил дэх эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжиж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх								
1	Эмэгтэй төлөөлөгчдийг хамруулан “Сайн туршлагаа хуваалцъя” форум зохион байгуулах	2020-2021	АЗДТГазар	Эмэгтэйчүүдийн холбоо, сумдын ЗДТГазар, ИНБ, хэвлэл мэдээллийн байгууллагууд	6 сая	Форум зохион байгуулсан эсэх	Сайн туршлагыг хуваалцах форум 2019 онд зохион байгуулагдаагүй.	Сайн туршлага болсон ажлуудыг орон нутагт зохион байгуулж ажиллана.
2	Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих оролцоонд суурилсан сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	2020-2021	АЗДТГазар	Эмэгтэйчүүдийн холбоо, сумдын ЗДТГазар, ИНБ, хэвлэл мэдээллийн байгууллагууд	5 сая	Сургалт болон сургалтад хамрагдсан иргэдийн тоо	Манлайллыг дэмжих оролцооны сургалтыг 2019 онд зохион байгуулаагүй.	Эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоо нэмэгдэнэ.